



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 07 өдөр

Дугаар

А/132

Хэрлэн сум

Нэг цэгийн үйлчилгээний төвийн
үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3, 19.1.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэг үйлчилгээний төвийг стандартад нийцүүлэн 24 цагийн үйл ажиллагаатай болгож, шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэхэд зориулж 20,000,000 (хорин сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Жендэрийн чиглэлээр орон нутагт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
03 дугаар сарын 07-ны өдрийн
А/152 дугаар захирамжийн хавсралт

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын нэр	Хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Түр хамгаалах байрны харуул, хамгаалалтын ажилтны цалин	12 сар	880.000	10.560.000
2	Нэг цэг үйлчилгээний төв, түр хамгаалах байрны тохижилт	Шаардлагатай тоног төхөөрөмж, тавилга	-	9.440.000
	Бүгд үнэ			20.000.000